

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXX (463)

2016

(244-248)

ГУРВАН ТӨРД ЗҮТГЭЖ, ХОЁР ТӨРИЙГ “ОНОСОН ЗҮТГЭЛТНИЙ ТУХАЙД”
До.Цэнджавын “Эрдэнэ жонон ван Ширнэндамдин” бүтээлийн тухай шүүмж

Ч. Баттулга *

Үргэлжилсэн үгийн зохиолын нэрт мастер До.Цэнджавын “ЭРДЭНЭ ЖОНОН ВАН ШИРНЭНДАМДИН” хэмээх нэгэн шинэ бүтээл мэндэллээ. Энэ нь сүүлийн үед хүмүүсийн хамгийн их уншиж сонирхох болсон баримтат-уран зохиолын чиглэлийн бүтээл ажээ.

Уран зохиол зохиолд үүрэг, түүх бичлэгт “үндэстний” зарчим бий юу?

Социализмын үед Маркс, Энгельс, Ленин, Сталины онол сургаалын үндсэн дээр сурагч багачуудыг *хувьсгалт шинэ үзэл мэдрэлтэй* болгон хүмүүжүүлэхэд хэл уран зохиол, түүх, нийгэм судлалын хичээл онцгой үүрэгтэй, урлаг утга зохиол нь тодорхой үүрэгтэй, түүх нь бичлэгийн “тусгай” зарчимтай гэгдэх төдийгүй социалист-коммунист нийгэм, марксист-ленинист ертөнцийг үзэх үзэл, ёс суртахууны итгэл үнэмшилтэй хүнийг бүтээх үзэл суртлын гол зэвсэг болж байв.

Харин өнөө үед, *Урлаг, уран зохиол зохиолд үүрэг байх албагүй*, хэн юу ч бичиж туурвиж болно, хэн нэгний уран бүтээлийг “цензүрдэж” болохгүй, *түүх бичлэгт “тусгай” зарчим буюу үзэл суртлын үүднээс түүхийг засварлаж болохгүй* гэх үзэл давамгайлах болжээ.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг ардчилсан нийгэмд энэ мэдээжийн хэрэг мэт боловч анхаарч бодууштай зүйл байна.

Үзэл суртал гэж юу вэ? Үзэл сурталгүй нийгэм, цаг үе гэж бий юу. “Үзэл сурталгүй байх ёстой гэдэг нь Америкийн өөрийнх нь үзэл суртал” гэсэн хошигнол ч бий.

Өнөөгийн үзэл суртал бол Үндэсний үзэл. Үндэс угсаа, хүн ардаа хамгаалах бодлогогүй улс гүрэн гэж энэ дэлхийд байна уу. Энэхүү үндэсний үзэл буюу “Үндэстний зарчим” урлаг утга зохиол, түүх бичлэгт ямар нэг байдлаар хадгалагдаж байх ёстой.

Энэ талаар судлаач Х. Ганхуяг, А.Баатархуяг нар “Монголын түүх бичлэг ба түүхэн социологийн асуудлууд” өгүүлэлд:

1. *Аль ч үндэстэн түүхээ бичихдээ үндэсний зарчмыг хатуу баримталдаг.*
2. *Аль ч түүх бичлэгт үндэсний баатруудаа бүтээдэг ба Барон Унгерн мэтийн гадаад баатар огт байдаггүй.*

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

3. Түүхэн зүтгэлтнүүдийн алдааг хэт шүүмжилж “түүхийн шүүгч” хийхийг зохисгүй гэж үздэг.

4. Түүхэнд заавал тайлбарлах албагүй, шаардлагагүй үеүд олон байдаг.

5. Аль ч түүх бичлэг хамгийн “зөв”, “шударга” түүх биш, залуу үеэ хүмүүжүүлэх түүх бичихийг хичээдэг.

6. Түүхэн гүн ухаан, онолын социологи мэдэхгүй бол түүх бичнэ гэж битгий горьд, мөн системийн анализ мэдэхгүй бол түүх бичлэгээр тоглохоо боль.

7. Монголын түүхийг гадаад төслийн мөнгөөр болон заавраар бичдэггүй. Телевизийн баримтат кинонууд бол гадаад төслийн нэг хэлбэр мөн...¹ гэснийг анхаарахгүй байж хэрхэвч болохгүй.

Мөн өгүүллээс эдүгээ Хятад, Орос зэрэг томоохон улс үндэстэн уул зарчмын үүднээс түүхээ хэрхэн бичдэг жишээг бэлхэнээ уншиж болох тул энд илүү олон зүйл нурших илүүц буй за.

Харин эрдэмтэн, зохиолч Долгорын Цэнджавын “Эрдэнэ жонон ван Ширнэндамдин” хэмээх түүхэн ойллого бүтээл нь яахын аргагүй “үндэстний зарчим”-ыг баримталж бичсэн судалгааны ажил болжээ. Мөн судлаач хүний цуцашгүй эрэл хайлт, уйгагүй их хөдөлмөр зүтгэлийн үр дүн гэдэг нь тодорхой юм. Дашрамд, мөхөс би зохиолчийн хөдөлмөрийг Цэнджав багшийн бүтээлээр харж ойлгох болсон хийгээд энэ олон зохиол бүтээл ямар их хөдөлмөрийн үр дүнд гардаг бол гэдгийг бодохоос яс хавтаймаар.

Төрийн хүний тэргүүн жишээ

Монголчууд хас төр энхжих нь хамт бүгдийн баяр буюу хэмээн амьдралын хувь заяагаа төрийн сүлдтэй холбож төрт ёсыг эрхэмлэн хүндэлж ирсэн уламжлалтай. Тийм ч учраас төрийн хүнийг сонгохдоо оюун ухаан, авъяас билэг, хууль ёс, эрдэм чадал, үүрэг хариуцлага, ёс зүй, аж төрөх ёсны бүхий л хүрээг хамарсан шалгуурын иж бүрэн тогтолцоог оновчтой цөөн үгээр томъёолж гаргасан байдаг билээ. (Хаан хүний 35 эрдэм, хатан хүний 15 эрдэм, түшмэл хүний 9 эрдэнэ..гэх мэт)

Мөн ямар шинж төгс бүрдсэн хүн төр засгийг барих /төрд ажиллах/ёстойг тов тодорхой заасан байдгийг Хубилай сэцэн хааны төр засах хөтөлбөр гэгддэг Монгол төр ёс, эрх зүй, гүн ухаан, түүх, уран зохиолын тулгар эх сурвалж болох “Арван буянт номын Цагаан түүх” бүтээлээр бид сайн мэдэх билээ. Үүнд:

.....Түүнчлэн ер хан хүн харьт гурван их үйлс, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их бэлгэ эд болой.

...Долоон **их бин** аль буй хэмээвээс

Нэгдүгээр, Өнгөрснийг хөөж онохуйн гүн ухааны бин

Хоёрдугаар, Ирээдүйг угтаж онохуйн дээд оточийн бин

Гутгаар, Битүүг таньж онох үлэмж мэргэний бин

Дөтгөөр, Эдүгээ ахуйг төгс онохуйн магад мэдэхуйн бин

¹ Х. Ганхуяг, А.Баатархуяг нар “Монголын түүх бичлэг ба түүхэн социологийн асуудлууд” www.ganaa.mn

*Тавдугаар, Бусад самбаа өгүүлэхүйн урьдаас онохуйн гайхамшиг сэцний бин
Зургаадугаар, Аян авын үйлийг ёсоор мэдэхүйн чадлын бин
Долдугаар, Таван ухааныг төгсгөхүйн гэгээн билгийн бин хийгээд буюу...*²

Энэ шалгуур, сургуулийг дүүргэсэн их хүмүүн бол хошой чин ван Цэрэндоржийн Ширнэндамдин болой.

Эрдэмтэн, зохиолч До.Цэнджав “Ширнэндамдин нь **...Гурван үеийн төрийн зүтгэлтэн** гэгддэг ч зохиогчийн итгэл үнэмшил, бодол, үзэмжээр бол **таван үеийн Монголын төрийн гарамгай зүтгэлтэн**, алтан аргамж болсон гадаад харилцааны том бодлоготон...” хэмээсэн нь нарийн учиртай аж.

Монгол төрийн хүн бол өөрийн амьдарч ахуй цагаасаа гадна өнгөрсөнг хөөж онохуйн, ирээдүйг угтаж онохуйн эрдэм чадал төгс байх ёстой гэж үзхүл Ширнэндамдин бээр гурван төрд зүтгэж, хоёр төрийг “оножээ”.

Мөн тэрээр “Амьдарч байсан бүх төрдөө жинхэнэ “төрд хэрэгтэй зайран” байж чадсан хүмүүний нэгэн бол яахын аргагүй Цэрэндоржийн Ширнэндамдин абугай мөн байна гэдгийг энэ номыг бүтээх зуураа, мөр тавих бүртээ бүрэн итгэлээ. Өмнө нь ингэж бодож ч байсангүй. “Төрийн долоон эрдэнийн нэг түшмэл” гэдэг эртний сургаал номлол үнэн байна. Энэ хүний амьдрал ахуйгаас илүү ойлголоо. Хуучин цагийн төрийн ХАР ТҮШМЭД гэдэг ямар агуу ертөнцтэй улс байж вэ? Гол нь Монголдоо голоо тасартлаа зүтгэгсэд юм. **Өнөөгийнхэн бол эднийхээ ясан дээр тоглож байгаа сахилгагүй хүүхдүүд шиг санагдана. Түүхийг сануулж, түүхэн зүтгэлтнүүдийг сануулж байх нь өнөөгийнхэнд өөрсдийгөө толинд харах мэт зэрэгцүүлэхэд ял мэт сонсогдож магад, гэвч сургамж, ухаарлын, ирээдүйгээ харах бүхэл бүтэн Их сургууль юм. “ТҮҮХ БОЛ ИРЭЭДҮЙ”³** гэжээ.

Үнэхээр, “Эрдэнэ жонон ван Ширнэндамдин” бүтээл “Монгол улсын үндсэн хууль” (3-р бүлгийн 1. 21.3-д “УИХ-ын гишүүнээр хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно”), “сонгох, сонгогдох эрх” гэгчээр далайлган дурын нэгэн төрийн жолоо атгадаг самуун цагт төрсөн нь ч учир ерөөлтэй юм.

Учир нь уг бүтээлийг уншсан хэн бүхэнд өнөө цагт монгол төрийн хүнийг сонгохдоо (УИХ-ын гишүүн, өндөр дээд алба хаших хүмүүс) илүү нарийн шаардлага тавих нь зөв зүйтэй гэж санагдах нь гарцаагүй. Төрийн хүнийг бэлтгэдэг монгол уламжлалыг ч сэргээж, наанадаж л, Социалист нийгмийн үеийн төрийн албан хаагчдыг бэлтгэдэг байсан тэр сайхан дэг сургуулийг уламжилсан бол өнөөдөр Монголын нийгэм ийм сул дорой байхгүй байсан болов уу.

Иймд Монголын ирээдүй, хүүхэд залуус “Жинхэнэ төрийн хүн”-ий эх орон, ард түмнийхээ төлөө амь биеэ хайрлалгүй, сэтгэл зүрх, эрдэм чадлаа зориулдаг байсан энэхүү үлгэр жишээг уншиж мэдэн, санаж сэргэж, суралцаасай гэж хичээнгүйлэн хүснэм.

Өнөөгийнхэн бол эднийхээ ясан дээр тоглож байгаа сахилгагүй хүүхдүүд шиг санагдана гэсэн зохиогчийн гүн утга агуулгат өгүүлбэрийг ухахнээ, Нэгэн цагт, Язгуур угсаатны харц ардтай ураглахыг хориглодог байсныг ч эерэг талаас харах хэрэгтэй болов уу. Төрийн хүн удам дамжиж төрдөг ажээ.

² Арван буянт номын Цагаан түүх, (Монгол бичгээс хөрвүүлж, бусад эхтэй харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа, Р.Төрдалай), Уб, 2006

³ Д.Цэнджав, Эрдэнэ жонон ван Ширнэндамдин, Уб. 2016, 7 тал

Эфү

Жил гаруйхны өмнө, Цэнджав багш надаас нутаг ус асуугаад “Архангайн Чулуутынх” гэсэн чинь “танай нутгийн” Наянт вангийн тухай олон сонин соргог баримт мэдээлэл удахгүй хэвлэгдэх Хошой чин ван Цэрэндоржийн Ширнэндамдингийн тухай номдоо оруулсан тухайгаа хуучилсан юм.

Ном ч гарч, зохиолч маань Наянт вангийн тухай “*Наянт вангийн алга тэнийж алдарт Данжуурыг залж авчирсан түүхээс*” /420-453/ гэсэн нэг бүлэг зориулжээ. Үүнийгээ

Би яагаад түүнийг /Наянт ванг/сонирхоод байна гэхлээр:

Нэгд: Ширнэндамдингийн ойр дотны андын холбоотойн хувьд,

Хоёрт: Манайхны ном соёлын дэлхийд гайхуулах өв, сан хөмрөг болсон “Монгол Данжуурын” 226 боть судрыг үнэ хөлсгүй өгч, түүний гэртээ бичиг нь Монголын Үндэсний номын сангийн үүдэн хойморт чулуун дээр ярайн заларч байдаг болохоор нэлээд дээр үеэс энэ чухам хэн бэ? гэсэн шохоорхол төрсөөр байсан юм.

Гуравт: Муу нэртэй, луу данстай түүнийг одоо ч ойлгохгүй байгаад,

Дөрөвт: Манжийн эфү гэхлээр л урваач, шарваачнаар дууддаг, хочилдог, ялладаг нэн хорсолтой үг хэллэг бий. Бие хүний, нутаг хошууг хүртэл түүгээр гоочлон шороо цацдаг нь сонгууль зэргээр мэр сэр гарч ирдэг учир тэр эфү гэгчид ямар хүмүүс байдаг юм бэ? гэсэн бодол төрдөг юм⁴ гэв.

Товчхондоо бол, Энэхүү бүтээл Монголын түүхэн дэх Эфү хэмээх ойлголтыг эерэг талаас ойлгоход маш тус болсон судалгаа шинжилгээний ажил юм. Нөгөөтэйгүүр, Наянт вангийн амьдрал үйл хэргийг үнэн бодтойгоор судалж шинжлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан бүтээл болжээ.

Тэрээр Наянт ванг “Түүхэнд Наянт вангийн нэр зурвас цохогдон гарах боловч чухам хэн бэ? гэдэг нь сайн тодорч өгдөггүй хэвээр байна. Нэгэн зуур эфү хэмээх Наянт ван Сайн ноён хан аймгийн шадар сайд захирагч нэртэй боловч Бээжин газар насаараа жасаалан сууж байжээ. Гэвч эфү Наянтын цээжинд Монгол нутаг тэр чигээрээ явсан байна. Хойшоо хараад амьсгал авахад Арын сайхан хангий, Чулуут гол минь санагддаг, даанч Бээжинд уяатай гадсыг ялтай билээ, ботголох гэж байгаа ингэ мэт шилэрч хүлжихсан гэж өөрийн итгэлт монгол ноёдод хэлдэг байжээ. Тэрбээр манж, хятадын хоёр талд ажилладаг дүрийг эсгэвч, Монголын талд хэцүү бэрх хэрэг явдлын түймэр тавьж, сүйд хийхгүйгээ мэддэг, их гүрний дээрэнгүй бодлогын аюул осолтой зүйлийг өөр тийш нь эргүүлдэг, бололцоо боломж таарангуут маш чухал нууц зүйлийг Богдод болоод Ширнэндамдинд сэмхэн дамжуулж мэдээлдэг “монголоо алдаагүй” сэтгэлтэй хашир бэрх тагнуулч, туршуулч байсан байх юм”⁵ хэмээн дүгнэн бичжээ.

“Зохиолын гол баатар” Ширнэндамдин нь Наянт вантай ойр түнш байсан, түүнд итгэдэг байснаа, Дотоод яаманд хоёр удаа өчиг мэдүүлэхдээ нуулгүй хэлж байсан, мөн

⁴ Д.Цэнджав, Эрдэнэ жонон ван Ширнэндамдин, Уб. 2016, 446 тал

⁵ Д.Цэнджав, Эрдэнэ жонон ван Ширнэндамдин, Уб. 2016, 447 тал

Наянт вантай хамтарч улм орныхоо тусгаар тогтнолын төлөө хэрхэн тэмцэж байсан тухай:

*Тэр ердөө ганцхан хүнийг онцлон хэлсэн нь Наянт Ван байдаг. Ингэх нь ч аргагүй. Наянт вантай ил далд уулзахдаа онц чухал мэдээ авч, түүнийгээ Богд хаанд дамжуулдаг байлаа. Найдвартай улаачаар үе үе маш нууц бичиг захидлыг илгээдэг, дамжуулдаг байв. Томчуудтай түүний нэр нүүрээр л уулздаг ярилцдаг байв. Нэг ёсондоо Наянтныг өөрийн талд итгүүлэн бүрмөсөн татаад, эцэстээ өөртөө нөмөр нөөлөг, мэдээ дамжуулагч болгосон нь Ши-гийн гавъяа юм. Ар халхын дотоод байдлыг ч Наянтад нуулгүй хэлнэ.*⁶

*Эфү Наянт ван хэдийгээр муу нэр, луу данстай ирсэн боловч Манжийн хаан болоод ар Монголын Богд хутагтын хоёр талд ажиллаж Монголыг манжаас тусгаарлахад маш нууц мэдээ, зангийг Ширнэндамдинд өгч “одоо хөдлөх цаг болжээ” гэж хэлсэн нь түүхэн чухаг үйлс мөн. Үнэндээ тэрбээр монголынхоо талд илүүтэйгээр тагнуул туршуулын албыг гүйцэтгэж байсан нь өдгөө батлагдсаар байна.*⁷

Мөн энэ бүтээл Наянт ван хийгээд Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны ноёдын Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, амьдрал үйл хэргийн үнэн мөнийг судлан тогтоох том ажлын түүчээ болсон нь гарцаагүй. Энэ хүрээнд ШУА-ын ХЗХ-ийн эрдэмшинжилгээний ажилтан, доктор Т.Баясгалан болон бидний нөхдийн санал санаачлагаар энэ жилд эрдэм шинжилгээний хурал зохиохоор төлөвлөж буй бөгөөд энэхүү хуралд эрхэм эрдэмтэн зохиолч маань сонирхолтой илтгэл яриа өрнүүлнэ гэдэгт үл эргэлзэнэ. Бас Цэнджав багш маань алдарт жанжин Дэмидийн тухай “Өрлөг жанжин” хэмээх сайхан тууж бичсэн агаад эдгээрт Арын хангайхан бид ач хариулах өртэй үлдлээ.

Төгсгөлийн үг

“Гурван төрийн нүүр үзсэн хүн” гэж дуулсанаас “таван төрийн нүүр үзсэн хүн” гэж сонсоогүй байх. “Таван төрийн нүүр” үзсэн хүний тухай ийнхүү бичнэ (Бусад бүтээл хамаарна) гэдэг таван төрийн нууцад нэвтэрсэн гайхамшигт зохиолч, эрдэмт хүний л бүтээх ажил ажгуу. “Таван төрийн нүүр үзсэн” эрхэм зохиолчийн бүтээлээс тавхан үг зориглон хэлэхэд л ийм бөлгөө.

⁶ Мөн тэнд 449 тал

⁷ Мөн тэнд 451 тал